ДУНДГОВЬ АЙМАГ
## ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
## ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 11 өдөр Дугаар А/54 Амардалай

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.7, 32.1.9, 32.1.10, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт, Хүнс Хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/76 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1."Бэлчээр хамгаалах өдөр"-ийн хүрээнд үлийн цагаан оготнотой микробиологийн аргаар тэмцэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Золжаргал /Засаг даргын орлогч/

Гишүүд: Г.Сосорбурам /2-р багийн Засаг дарга/

П.Мөнхзориг /1-р багийн засаг дарга/

Б.Гарьдмагнай /ХХААТ-ийн мэргэжилтэн/

Г.Дэжидсүрэн /Хөдөлмөр халамжийн үйлчилгээний мэргэжилтэн/

Б.Энхдэлгэр /Байгаль орчны байцаагч/

2. Микробиологийн аргаар тэмцэх арга хэмжээг зохион байгуулахдаа КОВИД-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлж, халдвар хамгаалал, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах, аюулгүй ажиллагааны зааварчилгааг нарийн чанд мөрдөж ажиллахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3. Тухайн ажлыг зохион байгуулахдаа холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэн, малын бэлчээрт үр дүнтэй ажил зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагчид даалгасугай.

4. Тус арга хэмжээг зохион байгуулахад зарцуулагдах зардлыг тооцож гаргахыг ЗДТГ-ын дарга /С.Нарантунгалаг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА М.БАЯРСУХ

488010 160